

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ"  
ХХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар  
/дүгээр/ сарын 19-ны өдрийн 26/197  
тоот тушаалын хавсралт 1



SOLOMON INVESTMENTS

## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Баримт бичгийн төрөл/ Type:

Ногдол ашгийн бодлого

Хамрах хүрээ/ Area:

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ" ХХК-  
ИЙН холбогдох ажилтнуудад

Нууцын зэрэглэл/ Confidentiality:

Дотоодод нээлттэй  
m/26/31

Баримт бичгийн дугаар/Number:

Боловсруулсан/ Prepared by:

Төлөөлөн удирдах зөвлөл

Баталсан/ Approved by:

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ" ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

Хуудасны тоо/ Page number:

3 хуудас

Хянан нийцүүлэх давтамж:

минд 1 удаа

Батлагдсан огноо/ Effective date:

2026 оны 03 дүгээр сарын 19

## НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журам нь "Соломон Инвестментс ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Ногдол ашгийн бодлого (цаашид "Бодлого" гэх)-ийн зорилго нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, ногдол ашиг хуваарилахтай холбоотой бодлого, зарчим, нөхцөл, журмыг тодорхойлоход оршино.
- 1.2. Энэхүү бодлогыг Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн дүрэм, Компанийн засаглалын кодекс болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно.

### ХОЁР.БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗАРЧИМ

- 2.1. Компанийн ногдол ашгийн бодлого нь дараах зорилгыг хангахад чиглэнэ. Үүнд:
  - 2.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх;
  - 2.1.2. Компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах;
  - 2.1.3. Компанийн урт хугацааны өсөлт, хөгжлийг дэмжих;
  - 2.1.4. Ногдол ашиг хуваарилалттай холбоотой шийдвэрийн ил тод байдлыг хангах;
  - 2.1.5. Бүх хувьцаа эзэмшигчидтэй тэгш, шударга харьцах.
- 2.2. Компанийн цэвэр ашиг, мөнгөн урсгал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, бизнесийн өсөлтийн хэрэгцээ, эрсдэлийн түвшинг харгалзан ногдол ашиг хуваарилна.

### ГУРАВ.НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЖУРАМ

- 3.1. Компани татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:
  - 3.1.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
  - 3.1.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
  - 3.1.3. компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 3.2. Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/ нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд уг шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах ба энэ баримт бичгийн 3.1-т заасан нөхцөл хангагдсан байна.
- 3.3. Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг дагаж мөрдөнө.
- 3.4. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.
- 3.5. Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.
- 3.6. ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.

- 3.7. Ногдол ашиг тараасны дараа үлдэх ашгаас нийгмийн хариуцлага, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болно. Сан байгуулах, түүний хөрөнгийг захиран зарцуулах журмыг гүйцэтгэх удирдлага боловсруулж, ТУЗ-ийн тогтоолоор батална.

### **ДӨРӨВ. НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ**

- 4.1. Ногдол ашгийн хэмжээг ТУЗ дараах хүчин зүйлсийг харгалзан тогтооно.
- 4.1.1. Тайлант жилийн цэвэр ашиг;
  - 4.1.2. Хуримтлагдсан ашиг;
  - 4.1.3. Мөнгөн урсгалын төлөв;
  - 4.1.4. Эрсдэлийн үнэлгээ;
  - 4.1.5. Ирэх жилийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ.
- 4.2. Компани нь татварын дараах цэвэр ашгийн тодорхой хувийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилах бодлого баримтлах бөгөөд ТУЗ шаардлагатай гэж үзвэл санхүүгийн нөхцөл байдалд үндэслэн хувийг тухайн үед тогтоож болно.
- 4.3. Нэг төрлийн хувьцаанд ижил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

### **ТАВ. ИЛ ТОД БАЙДАЛ БА ТАЙЛАГНАЛ**

- 5.1. Компанийн ногдол ашиг хуваарилахтай холбоотой шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд тухай бүр мэдээлнэ.
- 5.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд ногдол ашиг хуваарилалтын талаарх мэдээллийг тусгана.

### **ЗУРГАА. БУСАД**

- 6.1. Ногдол ашгийн бодлогыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 6.2. Энэхүү бодлогоор зохицуулаагүй харилцааг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.